

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийн тухай товч танилцуулга	2
1.2. Уурхайн байршил	2
1.3. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.4. Уурхайн жилийн хүчин чадал, уулын ажлын горим	3
1.5. Уурхайн цахилгаан хангамж	3
1.6. Уурхайн дулаан ба усан хангамж	4
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	4
2.1. Нийгэм эдийн засаг, дэд бүтцийн тодорхойлолт	4
2.2. Байгаль орчин	4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	6
3.1. Шууд нөлөөлөл.....	6
3.2. Шууд бус нөлөөлөл	6
3.3. Богино хугацааны нөлөөлөл.....	6
3.4. Урт хугацааны нөлөөлөл.....	6
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	7
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	8
6. хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11
8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	12
9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	13
11. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	14
13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	15
14. Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	15
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	16

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

Төслийн нэр: Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Болоржонш” ХХК-ийн “Зүүн Аргатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Болоржонш” ХХК нь Монгол улсын 9019087082 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй. 2830701 регистертэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дундговь аймгийн Баянжаргалан сум, Аргатай 2-р баг


Талбайн хэмжээ: 33.49 га

1.2. Уурхайн байршил

Төслийн байршил: Болоржонш ХХК-ийн Зүүн Аргатай хайлуур жоншны орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт тал хээрийн болон говийн бүсийн заагт 33. 49 га талбайг эзлэн оршино. Уг орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 250 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 100 км зайд оршино.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	107	57	31.51	45	33	51.61
2	107	57	31.51	45	34	16.61
3	107	57	51.51	45	34	16.61
4	107	57	51.51	45	33	51.61



Зураг 1. Төслийн ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайн байршил (М1:100000 байрзүйн зураг дээр, L-48-96)

1.3. Төслийн ерөнхий мэдээлэл

“Болоржонш” ХХК нь “Зүүн Аргатай”-н ордын 33.49 га талбайд хайгуулын 6628Х тоот тусгай зөвшөөрлийг авсны үндсэн дээр 2005-2006 онд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг хийж, хайлуур жоншны нөөц тооцон үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд уг хурлаас “Хайгуулын ажлыг гүйцээн нарийвчилж, нөөцийг бодитой (В) зэргээр тооцоолох” шийдвэр гарсны дагуу 2009-2011 онуудад нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 2006 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар /хуучин нэрээр/-ын ГУУКА-аас ашиглалтын 11820А тоот лицензийг авсан байна.

MV-011820А тоот бүхий ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу “Зүүн-Аргатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглахаар төлөвлөж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хэмжээ 33.49га бөгөөд “Зүүн-Аргатай” хайлуур жоншны ордын геологийн бодит (В) нөөц 448604.67тн, үйлдвэрийн нөөц нь 460659.34тн байна.

Хайлуур жоншны ордыг гадаад болон дотоод овоолго бүхий автотээвэртэй ашиглалтын системээр гидравлик экскаватор-өөрөө буулгагч автосамосвалын хослолыг хэрэглэн ашиглалт явуулахаар төлөвлөсөн.

1.4. Уурхайн жилийн хүчин чадал, уулын ажлын горим

2025 онд уурхайгаас 10.0 мян.м3 хөрс хуулна. Ашиглалтын үеийн бохирдлын хэмжээг ТЭЗҮ-д тооцогдсоны дагуу бохирдол 2.3 %, хаягдал 1.5 % байхаар тооцлоо. 2025 онд В-2 блокоос 35.51 мян.тн, В-3 блокоос 44.49 мян.тн хүдэр олборлоно. 2025 онд 57.55 %-ийн дундаж агуулгатай 80.001 мян.тн хүдэр олборлохоор тооцоолсон.

Ил уурхай дулааны улирлын 200 хоногт 8 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжийн горимоор ажиллана. Уурхайд хөрс хуулалт, хүдэр олборлолтонд 1.0 м³ -ийн шанагатай ZX 450Н маркийн экскаватор 1 ш, 20 т даацтай Нowo автосамосвал 7 ш, 3.0 м³ утгууртай дугуйт ачигч 2 ш, уулын үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүд байна.

Хүснэгт 2.Уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	180
Жилд ажиллах сар	сар	6
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	1
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	10
Жилд ажиллах хугацаа	хоног	160

1.5. Уурхайн цахилгаан хангамж

Уурхайд эрчим хүч шаардах томоохон хэрэглэгч байхгүй тул хүдэр ангилан ялгах төхөөрөмж, орон сууц болон бусад объектуудыг гэрэлтүүлэх, засварын газрын зарим цахилгаан тоног төхөөрөмж /токарийн машин, цахилгаан өрөм, гагнуурын аппарат г.м/ зэргийг ажиллуулахад зориулж ДЭС-100 цахилгаан үүсгүүрийг ашиглаж байна.

1.6. Уурхайн дулаан ба усан хангамж

Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа 160 хоног тул хүмүүсийн оршин суух байр болон засварын зориулалттай вагончик зэргийг ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

Уурхайн ундны усны хэрэглээний усыг өөрийн үйлдвэрээс зөврөөр шийдэнэ.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засаг, дэд бүтцийн тодорхойлолт

Зам харгуйн хувьд орон нутгийн энгийн шороон замуудтай, хавь ойрын суурин газар, төвүүдийн хооронд шууд холбогдсон байдаг. Талбайн аль ч хэсгээр жилийн ямар ч улиралд явах боломжтой, харин томоохон хөндийнүүд нь зуны бороотой үед хужиртай тойром, намагтай болдог тул тэр болгон зам харгуйн хэсгээр туулах боломж муу байдаг.

Хүн ам цөөнтэй, гол төлөв малчид нүүдэллэн амьдардаг, 1км² талбайд 0.2-0.6 хүн ноогддог, хүн ам арай шигүү сууршилттай нь Говь-Угтаал, Баянжаргалан сумын төв, Морьт, Хонгор, Энгэр-Усны багийн төвүүд юм. Тэнд сургууль, цэцэрлэг, холбоо, эмнэлэг, дизель станц, дэлгүүр, худалдаатай. Сүүлийн үед Бумбат, Сүүл өндөр, Зүүн, Баруун цагаан овоо, Хавиргад жоншны жижиг уурхайнууд ажиллаж эхэлж байна. Талбайн орчинд өндөр хүчдэлийн шугам байхгүй, Улаанбаатараас 320 км, Чойр хотоос 100 км зайд тусгай зөвшөөрлийн талбай оршдог ба ойр орчны уурхайнууд нь эрчим хүчээ дизель станц ажиллуулж гаргаж авдаг.

2.2. Байгаль орчин

Физик газарзүйн нөхцөл

“Болоржонш” ХХК -ийн “Зүүн-Аргатай” хайлуур жоншны орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн урагш 320 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 100 км зайд оршино. Ашигт малтмал ашиглах MV-011820 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ нь 33,49 гектар юм.

Газрын гадаргуу

Гадаргуугийн хувьд далайн түвшингээс дээш 1100-1200 м өргөгдсөн жижиг толгод гүвээ хэлбэрийн мөлгөржсөн хэсэгт багтан, Хэнтийн нурууны төгсгөл, говийн бүсийн эхлэлийн зааг бүс хэсэгт оршдог. Хамгийн өндөр цэгүүд нь далайн түвшингээс дээш 1305-1320 м -т өргөгдсөн товгор уулс бөгөөд тэдгээр нь харьцангуй залуу гүний чулуулгаас тогтох учир барзгар гадаргуутай, эргэн тойрон 20-50 км зайд харагдалт сайтай байдаг. Урагшлах тутам газрын гадаргуу намсч, мөлгөржин жижиг гүвээ, толгод болон хувирдаг ба харьцангуй өндөржилт нь 10-50 м -ээс хэтэрдэггүй.

Ус зүй

Тухайн районы нэг онцлог нь тогтмол урсацтай гол горхи байдаггүй. Зөвхөн Аргатай, Элгэн, Гашуун хар, Хужирт зэрэг жижиг булгуудтай, харин уужим хөндийнүүддээ хужиртай жижиг шанд тойрмууд нилээд элбэг байдаг. Хөндий амууддаа худаг элбэг,

тэдгээрийн дебит нь 200-1600 л/цагт хэлбэлздэг боловч ихэнх усны чанар нь ундааны усанд тохиромж муутай байдаг.

Цаг уур

Тухайн район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, улиралын ба хоногийн температурын хэлбэлзэл ихтэй, хур тунадас багатай хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын (1938-1998 он) дунджаар хамгийн хүйтэн 12, 1 -р сард болдог ба -23 ~ -24°С, хамгийн халуун үе 6 -аас 8 -р сард болдог бөгөөд +25 ~ +30°С орчим болдог. Жилийн дундаж хур тунадас 113 мм ба үүний дийлэнх хэсэг нь 6 -аас 9 -р сард (90 мм) бороо хэлбэрээр буудаг байна. Салхи гол төлөв баруун хойноос зүүн ургаш чиглэлтэй, салхины жилийн дундаж хурд 4.7 м/сек гэх боловч хавартаа 15-20 м/сек хүрэх тохиолдол элбэг байдаг.

Хөрс, ургамал

Шимт хөрсний зузаан 5-20 см, цөөн тохиолдолд 40 см (нуур орчим) хүрдэг, хүрэн, бор өнгөтэй, ургамалын бүрхэвч сийрэг, түүний төрөл цөөн, голдуу таана, хүмүүл, агь, божмог, шарилж, зангуу ургадаг, харин нуур тойрмоо дагаж бага хэмжээгээр нугын янз бүрийн ургамал ургана. Модгүй, жалга, нугачаа дагаж, цөөн тоогоор хайлаас, тоорой энд тэнд ургасан байдаг, Мөн бага тархацтай, буйлс, дэрс, харгана, тоорой ургасан нь тохиолдоно.

Ан амьтан

Амьтны ертөнц нилээд олон төрөлтэй, араатан амьтдаас үнэг, чоно, мануул, хярс, дорго элбэг. Харин уулархаг хэсэгтээ цөөн тоогоор аргаль, янгир, тал хэсэгтээ нилээд олноор зээр, хар сүүлт тохиолдоно. Жигүүртний аймгийн төлөөлөгчид хамгийн элбэг: бүргэд, харцага, тоодог, тогоруу, ногтруу, болон бусад жижиг шувууд олон байдаг. Хавар, намартаа хачиг ихтэй, зун, намартаа царцаа, голио, гүрвэл, дэлэнч их хэмжээгээр байдаг, хортой могой элбэг тул болгоомжлох нь зүйтэй.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар дараах зөвлөмжүүдийг өгч байна. Ашиглалт, хаалтын үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөллийг хамгийн бага хэмжээнд хүртэл багасгаж ажиллах нь зүйтэй.

3.1. Шууд нөлөөлөл

Байгаль орчин, экологид үзүүлэх болзошгүй нөлөөллийн 7 нь шууд нөлөөлөлд хамаарахаар байна. Эдгээрт уурхайн тээвэрлэлтээс шалтгаалж хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын бүтэц өөрчлөгдөх, ахуйн бохир ус, хог хаягдлын цэгийн ариутгалыг муу хийснээс орчин бохирдох, хөрсний бохирдол үүсэх нөхцлийг бүрдүүлж байна. Мөн уурхайн үйл ажиллагаа нь сумын дэд бүтцийн хөгжил, хүн ам, орлого нэмэгдэх, ядуурлыг бууруулах, ажлын байр бий болоход нэмэр болох сайн талтай юм.

3.2. Шууд бус нөлөөлөл

Олборлолтын явцад амьтдаас шавьжны төрөл зүйл дайжих явдал гарах, мөн тээвэрлэлт явуулсанаар агаарт тоосжилт үүсэх, анхаарал болгоомжгүйгээс гал гарах зэрэг нөлөөлөл байж болно.

3.3. Богино хугацааны нөлөөлөл

Цаг агаарын хуурайшилтын үед машин механизмын үйл ажиллагааны дүнд тоос агаарт гарах, хүнд механизмын хөдөлгүүрийн дотоод шаталт зэргээр агаарыг богино хугацаанд түр бохирдуулж, ажиллагсадын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, ойр орчмын хөрс, ургамал, талбай тоосонд дарагдаж өөрийн унаган төрхөө алдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржихэд хүрч болох нь мөн богино хугацааны нөлөөлөлд хамаарна. Иймд салхи ихтэй үед тээвэрлэлтийн ажил хийхгүй байх, тоос шороог багасгах шаардлагатай тохиолдолд усалгаа хийх зэрэг нэмэлт арга хэмжээг авч байх нь зүйтэй. Хог хаягдлын цэгийг тогтсон хугацаанд ариутгаж байх хэрэгтэй.

3.4. Урт хугацааны нөлөөлөл

Дээрх хүснэгтээс үзэхэд олборлолтын явцад байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн 9 нь удаан хугацаагаар нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд: ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, геологийн тогтцын өөрчлөлт, хөрсний бохирдол зэрэг сөрөг нөлөөллөөс гадна дэд бүтцийн хөгжил, хүн амын болон нутгийн орлого нэмэгдэх зэрэгт буцалтгүй эерэгээр нөлөөлөхөөр харагдаж байна. Буцаж нөлөөлөх нөлөөлөл гэдэг нь ахуйн хог хаягдлыг ариутгал хийгээгүйгээс хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөллөхийг хэлдэг.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчин бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах үндсэн зорилготой.

Тус төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан. Тухайн жилийн БОМТ-ний нийт төсөвт 18.2 сая.төг зарцуулахаар төлөвлөсөн.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар						
1	Тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас тоосжилт үүсэх.	Цаг агаарын урьдчилсан мэдээг үндэслэн тоосжилтыг бууруудах төлөвлөгөөт усалгааны хуваарь гаргах	БО мэргэжилтэн боловсруулна.	-	Хуурайшилттай үед	MNS 5014:2003 MNS5010-2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS:4596:2007 Замын тэмдэг, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх журам
2		Тоосжилтыг дарах уурхайн замын усаглгаа хийх	Уурхайн бүс, зам талбай	800,000	Хуваарийн дагуу	
3	Утаа болон хийн бохирдол үүсэх	Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу техник хэрэгслийн татварыг төлөх	Хүнд даацын машин механизм	200,000	Төсөл хэрэгжих хугацаанд	
Хөрс, газрын гадрага						
1	Уурхайн ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна.	Орон нутагтай хамтран гэрээгээр зайлуулна.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Орон нутагтай хийсэн гэрээний дагуу	-Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг

2	үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон	ШТМ-ын зориулалтын саванд хадгалах	ШТМ хадгалах цэгт	300,000	Аудитын тайлангийн зөлөмж	тодорхойлох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3	ургамлыг гэмтээх, ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	ШТМ-ын хаягдал хадгалах талбайг хатуу хучилттай болгох	ШТМ хадгалах цэг	500,000	Аудитын тайлангийн зөлөмж	
4	ТХ-ийн явах эд ангиуд гэмтэх, ШТМ асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	Уурхайн авто зогсоол болон кемп орчмын тосоор бохирдсон хөрсийг цэвэрлэх.	Уурхайн авто зогсоол, кемп	200,000		
Усан орчин						
1		Үерийн далан шуудуунд бөөгнөрсөн хогийг тогтмол цэвэрлэж байх	Хог хаягдлын бөөгнөрөл үүссэн үед	200,000		Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль -ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ.
2	Ус ашиглах боломжит нөөцийн тооцоонд тусгагдсаны дагуу ариг гамтай ашиглах	Харъяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулах, төлбөр төлөх	Гэрээний дүнгээр		2025 он	
3		Гүний ус, байгаль орчинг бохирдуулахгүй байх анхааруулга, санамж бүхий самбар хийх	100,000			
Ургамал						

1	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устгах	Уурхайн тээврийн зам дагуу ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониторинг хийх	Тээврийн зам	200,000	6 сараас 8 сарын хооронд	Ургамлын мониторинг хийх аргачлал (шугаман цэгийн арга)
Нийт зардал:				2,500,000		

6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог ангилал	Хаягдлын Сөрөн нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	Уурхайгаас гарах хатуу хог хаягдал Гэрээний дүнгээр		ҮАЗ	Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх				
	Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах	Хуванцар Ахуйн Аюултай			
Аюултай	Ашигласан тос маслийг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	ШТМ хадгалах цэг		Гэрээний дүнгээр	
	Үйл ажиллагаанаас үүсэх хаягдал батерей, аккумулятор зэргийг	Уурхайн үйл ажиллагаа	150,000		

	зориулалтын цэгт ангиалан хадгалж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх			
Нийт			2,500,000	

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн ажлын явц дахь гэнтийн осол	Анхны тусламжийн иж бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлтгэх	Баяжуулах үйлдвэрийн бүс	200,000	2025 он	
2		ХАБЭА-н сургалтуудыг тогтмол зохион байгуулах		250,000	Жилд 1 удаа	
3		Уурхайн тэмдэг тэмдэглэгээг хэрэгцээт хэмжээгээр байрлуулах		300,000	2025 он	
4		Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх		ҮАЗ	Өдөр бүр	
4	Болзошгүй гал түймэр	Гал түймрээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл (галын		700,000	2025 он	Гамшгаас хамгаалах тухай хууль

		дохиолол, хүрз, элс, хөөс, аюулгүй байдлын самбар) болон гал гарсан тохиолдолд унтраах, хамгаалалтын багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулаж, дууссан тохиолдолд цэнэглүүлэх				
5		Галын дүгнэлтийг мэргэжлийн байгуулгаар гаргуулах		50,000		Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт зардал:				1,500,000		

8. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /төг/	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
1	Техникийн нөхөн сэргээлт	Орон нутгаас санал болгосон газарт	5,000,000	“Болоржонш” ХХК	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал
2	Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлэх	Шимт хөрс хадгалах талбай		“Болоржонш” ХХК	
Нийт зардал			5,000,000		

9. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардал /төг/	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
1	Дүйцүүлэн хамгаалах ажил	Аймаг, сумын ЗДТГ, тэдгээрийн асуудал хариуцсан байгууллага, орон нутгийн оролцогч талуудтай зөвшөөлцөний үүдэн сонгоно.	3,000,000	“Болоржонш” ХХК	
Нийт зардал			3,000,000		

10. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

11. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Зүүр аргатай хайлуур жоншны ордыг ашиглах” төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт- шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар				
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5, PM10, SO2, NO2	Тээврийн замын салхины дээд болон доод тал Уурхайн орчим Замтай ойр айл өрхийн дэргэд	Жилд 2 удаа	620,000	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
Гадаргын болон газрын доорхи ус				
Усны чанар: рН, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, BXX, XXX, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni,	Ус хангамжийн цэгт	Жилд 2 удаа	180,000	MNS (ISO) 5667- 5:2001- усны чанар- дээжлэлт
Ахуйн бохир усны цоонгийн бохир ус: рН, Ж/б, XXX, BXX, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, P- эрд	Ахуйн бохир ус	Жилд 2 удаа	180,000	MNS (ISO) 5667- 10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: рН,, чийгшил, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅	Уурхайн карьер Хөндөөгүй газар Тээврийн зам дагуу	Жилд 2 удаа	411,000	MNS3298-90 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS5850:2008 Хөрсний чанар.
Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Авто зогсоол Засварын газар Тээврийн зам дагуу	Жилд 2 удаа	340,000	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Эрүүл ахуйн шинжилгээ	Кемп(хог хаягдлын цэгийн ойролцоо)	Жилд 1 удаа	70,000	
Нийт зардал:			1,800,000 төг	

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал /төг/	Хариуцсан албан тушаалтан
1	Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах	Гэрээний дүнгээр		Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч
3	Орон нутгаас заасан цэгт тэрбум мод төслийн хүрээнд 100 ш мод тарих	5-6 сар болон 9-10 сар	1,000,000	“Болоржонш” ХХК
Нийт зардал			1,500,000	

14. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах ажилтан
1	БОУАӨЯ-д	Цахим хэлбэрээр	2025 оны БОМТ-ний биелэлтийн хүрээнд хийсэн ажил	2025 оны 4-р улирал	-	Байгаль орчны мэргэжилтэн
2	Орон нутгийн байгаль орчны байцаагч болон засаг дарга	Бичгэн тайлан		2025 оны 4-р улирал	200,000	Байгаль орчны мэргэжилтэн
3	Аймгийн байгаль орчны газарт	Шинжээчийн дүнгээр баталгаажна		2025 оны 4-р улирал	200,000	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал				400,000		

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	2,500,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,500,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,500,000
4	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5,000,000
5	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,000,000
6	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Түүх соелын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,800,000
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500,000
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	400,000
Нийт		18,200,000 төг